



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Анагаахын шинжлэх ухааны үндсэний их сургуулийн
Сувилахуйн Сургууль

Хөтөлбөрийн нэр: Сувилахуй бакалаврын сургалтын хөтөлбөр

Индекс: D091301

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Уламбаяр

Гишүүд: Г.Шүрэнмягмар

Ю.Оюунзул

Он сар өдөр: 2022.04.05-06

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	8
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	11
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	15
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	17
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	20
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	25
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	29
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	33
I. Багш нарын нэрс	33
II. Оюутнуудын нэрс	33
III. Ажил олгогчдын нэрс.....	34
IV. Төгсөгчдийн нэрс	34
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	35
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн нэгдсэн улс
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
АУДyC	Анагаах Ухааны Дунд Сургууль
АСШУТ	Анагаахын суурь шинжлэх ухааны тэнхим
БАС	Био Анагаахын сургууль
БМИУЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны яам
БХАХ	Багшийн хөгжлийн ажлын хэсэг
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЗХНГ	Захиргаа хүний нөөцийн газар
МУ	Монгол Улс
МТА	Мэдээлэл технологийн алба
МЯЭ	Монгол Японы эмнэлэг
НХСТ	Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхим
НЭМСТ	Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тэнхим
ОУСН	Олон Улсын Сувилагчийн Нийгэмлэг
ОХУГ	Оюутны хөгжлийн удирдлагын газар
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХҮГ	Хангамж үйлчилгээний газар
СБЗА	Сургалтын бодлого зохицуулалтын алба
СС	Сувилахуйн сургууль
ТӨСБЗГ	Төгсөлтийн өмнөх сургалтын Бодлого зохицуулалтын газар
ЭБЭХСТ	Эх барих, эх хүүхдийн сувилахуйн тэнхим
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭМШУТНС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны төв номын сан

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУҮИС, Сувилахуйн сургууль MNUMS, School of Nursing	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Сувилахуй, Nursing	
Индекс	D091301	
Шинжээчид	<p>Ахлагч: Л.Уламбаяр - Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн Мэргэжил дээшлүүлэх сургуулийн захирал, доктор</p> <p>Гишүүд: Г.Шүрэнмягмар - Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн Сувилахуйн тэнхимийн ахлах багш Ю.Оюунзул – Хавдар судлалын үндэсний төвийн Сувилахуйн албаны дарга</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.03.21	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. № А/63
	2022.03.25	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан
	2022.04.01	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.04.05-06	Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан.
		Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан.
		Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан
		Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн. /танхимаар/
	Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн. /онлайнаар/	
	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Сувилахуйн сургууль нь Монгол Улсад анх 1929 онд сувилагч бэлтгэж эхэлснээс өнөөг хүртэл мэргэжилтэн бэлтгэж буй 93 жилийн түүхтэй. Хөтөлбөр нь удирдлага, зохион байгуулалтын хувьд хөтөлбөрийн ерөнхий хороо, хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын хэсэг, хөтөлбөр хэрэгжүүлэх тэнхим, багш гэсэн уялдаа хамааралтай ажилладаг байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 8 ажлын хэсэг байгуулан, 7 тэнхим 76 багштай мэргэжлийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Хөтөлбөрийн зорилго, хэрэгцээ:

Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд хөтөлбөрийн зорилгыг тодохойлохдоо: Сувилагч мэргэжилтэнг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд чиглэсэн сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, бүх шатны эмнэлэг, сургууль, цэцэрлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад ажиллахаар бэлтгэхэд оршино.

Тус хөтөлбөр нь 2010, 2017 онд магадлан итгэмжлүүлж, 2022 онд 3 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэх гэж байна. Сувилахуйн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нь Монгол Улс төдийгүй дэлхийн хэмжээнд эрэлт хэрэгцээтэй байна. Тухайлбал: МУ-ын хэмжээнд хийгдсэн 2014-2020 оны эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалтад 2016 онд 7 дугаарт, 2017 онд 5 дугаарт, 2020 онд 8 дугаарт, АНУ-аас 2016 онд хийсэн нэн шаардлагатай мэргэжлийн судалгааны жагсаалтад “Сувилахуйн мэргэжил” 4 дүгээрт тус тус орсон байгаа нь эрэлт хэрэгцээтэй байгааг харуулж байна. Мөн Судлаач В.Даваахүү нарын “Сувилахуйн хүний нөөцийн хомсдлоос гарах арга зам” судалгаагаар эмнэлгийн тусламж үйлчилгээ шатлалыг холбогдох стандартуудтай харьцуулан судалсан судалгаанаас үзэхэд нарийн мэргэшил, төрөлжсөн эмнэлгүүдэд стандартад заагдсан хүний нөөцийн мэргэжилтнээс дунджаар 54 (36.1%)-оор, аймаг дүүргийн хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлэхээс дунджаар 18 (24.4%)-аар тус тус дутагдалтай байгааг гаргасан байна. Мөн Монгол Улсад эмч, сувилагчийн харьцаа 2021 оны байдлаар 1:1.6 цаашид 2026 онд 1:2 болох төлөвтэй байгаа нь ойрын 10 жилд эрэлттэй байгааг харуулж байна. Сувилахуйн сургалтын хөтөлбөр нь 2015-2016 онд (Blue print) сувилахуйн мэргэжилтний цогц чадамжийг боловсруулан ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн: PLOs (Program Learning Outcomes)

- Төгсөгчийн эзэмших 10 чадамж

Хичээлийн хөтөлбөрийн хүрэх үр дүн CLOs (Course Learning Outcomes)

- 63 мэдлэг
- 174 чадвар
- 62 хандлага эзэмшинэ

Дараах зарчмыг баримталж байна

- ДЭМБ-аас гаргасан Сувилахуй болон Эх барихуйн стратеги (2021-2025)-д тусгагдсан чанартай боловсрол (Quality education)-ыг хэрэгжүүлэх
- Сувилагчийн тоог нэмэгдүүлэх, чанарт анхаарах
- Сургалтын төлөвлөгөөг олон улсын жишигт нийцүүлэх
- Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

№	Хичээлүүд	Заавал судлах				Сонгон судлах		
		Хичээлийн тоо	Багц цаг	Нийт цаг	Эзлэх хувь	Багц цаг	Нийт цаг	Эзлэх хувь
1	Ерөнхий суурь хичээлүүд	11	21	1008	16%	4 (2 хичээл)	192	3%
2	Мэргэжлийн суурь хичээлүүд	12	28	1344	22%	2 (1 хичээл)	96	1.5%

3	Мэргэшүүлэх хичээлүүд	30	63	3024	48%	2 (1 хичээл)	96	1.5%
	Нийт	53	112	5376	86%	8 (4 хичээл)	384	6%
4	Дадлага	4	10	480	8%			
	БҮГД	57	122	5856	94%	8	384	6%

Хөтөлбөрийн багц цагийн харьцуулалт

№	Багц цагийн агуулга	Нийт багц				
		A/174	Сувилахуй 2015	Эзлэх хувь	Сувилахуй 2016	Эзлэх хувь
1	Ерөнхий суурь	30%-иас бага	28.0	20.6	25.0	20.8
2	Мэргэжлийн суурь	25%-иас бага	56.0	41.2	30.0	25%
3	Мэргэшүүлэх	45%-иас их	52.0	36.8	65.0	54.2%
4	Дадлага		10		10	
	Нийт		136.0	100	130.0	100

Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт

№	Хичээлийн чиглэл	Онол		Дадлага	
		Лекц	Семинар	Дадлага	Бие даалт
1	Ерөнхий суурь	160	256	224	560
		416		784	
2	Мэргэжлийн суурь	208	256	288	688
		464		976	
3	Мэргэшүүлэх	448	368	816	1488
		816		2304	
	Нийт хувь	1696 (29%)		4064 (71%)	

Хөтөлбөрийн онцлог:

- Сургалтын шинэ технологи, арга зүйг нэвтрүүлэх, уян хатан хөтөлбөр боловсруулах.
- Хөтөлбөрийн орц, гарц, явцыг үнэлэх, сайжруулалт хийхэд орчин үеийн үнэлгээний арга болох CIPP (context-Input-Process-Product) загварт суурилсан аргачлалыг ашиглаж байна.
- **“АШУУИС-ийн Сургалтын технологи чанарын хяналтын үлгэрчилсэн журам”-ыг** мөрдөн мэргэжлийн хөтөлбөрийн арга зүйг сургалтын SPICES дараах загвараар хэрэгжүүлдэг. Үүнд:
 - Student centered-оюутан төвтэй
 - Problem based-асуудалд суурилсан
 - Integrated-нэгдмэл
 - Community oriented-нийгэмд чиглэсэн
 - Elected-сонголттой
 - Systematic-системтэй аргыг ашиглан хэрэгжүүлдэг.
- ISO 9001:2015 байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн.
- Сувилахуйн тусламжийг хосолсон системээр үзүүлэх арга зүйг ашигладаг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн мэргэжилтний хэрэгцээ, шаардлагыг Монгол Улсын хэмжээнд хийгдсэн судалгааны ажлуудын үр дүн нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг ашиглан, тооцож хэрэгцээт мэргэжилтэн болохыг тодорхойлсон. Тухайлбал: Англи улсын “Tony Blair” сангаас 2013 онд хийгдсэн сувилагч мэргэжилтний хэрэгцээг хүн ам зүйн хэрэгцээнд үндэслэн тооцож гаргасан судалгаагаар 2016 оны байдлаар нийт ажиллаж буй сувилагчийн тоон үзүүлэлт 19768-д хүрч байж стандартад нийцэх байсан боловч 2020 оны байдлаар 13112 сувилагч ажиллаж **6656** дутагдалтай байна.
- Монгол Улсын хэмжээнд жил бүр эрэлттэй эхний мэргэжлийг тодорхойлдог Хөдөлмөр нийгэм хамгааллын судалгааны институтээс гаргадаг Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар 2020-д сувилагч эхний 8 дугаарт эрэмблэгдсэн байна.
- Хөтөлбөрийн багийн судлаач В.Даваахүү нарын “Сувилахуйн хүний нөөцийн хомсдлоос гарах арга зам” судалгаагаар эмнэлгийн тусламж үйлчилгээ шатлалыг холбогдох стандартуудтай харьцуулан судалсан судалгаагаар эмнэлгүүдэд сувилагч ямар ачаалалтай байгаа болон дутагдалтай байгааг гаргасан нь нотолгоонд суурилж эрэлт хэрэгцээг гаргасан байна. Тухайлбал нарийн мэргэшил, төрөлжсөн эмнэлгүүдэд стандартад заагдсан хүний нөөцийн мэргэжилтнээс дунджаар 54 (36.1%), аймаг дүүргийн хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлэхээс дунджаар 18 (24.4%) тус тус дутагдалтай байна.
- Үндэсний болон Олон улсын боловсролын чиг хандлагыг цаг алдалгүй судалж, баримжаалан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажилладаг байна. Тухайлбал ДЭМБ-аас гаргасан Сувилахуй болон эх барихуйн стратеги (2021-2025)-д тусгагдсан үндсэн зарчмуудын нэг болох Чанартай боловсролыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- Сургалтын хөтөлбөрийг гадаадын 3 сургууль (АНУ, Австрали, Филиппин)-тай харьцуулахад АНУ-ын хөтөлбөр 125.0 кредит цаг (Сувилахуй 4жил, 130.0 кредит цаг, зөрүү 5.0 илүү), Австралийн хөтөлбөр 3 жил, 144.0 кредит цаг (Сувилахуй 4 жил, 130.0 кредит цаг, зөрүү 14.0 дутуу), Филиппины хөтөлбөр 4 жил, 202 кредит цаг (Сувилахуй 4 жил, 130.0 кредит цаг, зөрүү 72.0 дутуу), дотоодын 1 сургууль Этүгэн их сургуулийн Сувилахуйн хөтөлбөр 4 жил, 136 кредит цаг (Сувилахуй 4 жил, 130.0 кредит цаг, зөрүү 6.0 дутуу) тус тус байна. Ялангуяа сувилахуйн тусламж үйлчилгээ, асаргаа сувилгааг өндөр түвшинд үзүүлдэг Филиппины хөтөлбөр мөн өндөр хөгжилтэй орны хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж, сайжруулалт хийж, боломжийг эрэлхийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжилтний цогц чадамж боловсруулсан
- Хөтөлбөрийн хороодын чиг үүрэг тодорхой, тогтмол ажиллаж, тасралтгүй хөтөлбөрийн сайжруулалт хийдэг.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэхэд хийгдэж буй судалгааны цар хүрээг өргөжүүлэх, тэдгээрийн санал, зөвлөмжид дүн шинжилгээ хийж, нэгтгэж, дүнг гаргаж боломжтойг нь хөтөлбөрийн сайжруулалтад тусгах

- Гадаадын хөтөлбөрийн нэг кредитэд оногдох цаг ялгаатай байгааг цаашид хөтөлбөрийн харьцуулалт хийхэд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Судалгаа, шинжилгээ, эрдэм судлалын ажил нилээдгүй хийсэн боловч түүний үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад тусгах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн болон Сувилахуйн сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг үндэслэн үндэсний (салбарын) болон олон улсын хөгжлийн чиг хандлагад чиглэсэн хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон
- Хөтөлбөрийн зорилт, агуулга, чиглэлийг оролцогч талуудын хэрэгцээ, мэргэжилтний ур чадварын шалгуур, үзүүлэлтийг үндэслэн тодорхойлсон.
- Нэгж хичээлээр олж авах чадамж, хөтөлбөрөөр олж авах чадамж зэрэг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарлыг харуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн. Нотолгоо (сургуультай хамтран ажиллах, төгсөгчдийг ажилд авах санал 96%) байна.
- Хөтөлбөрийн орц, гарц, явцыг үнэлж, сайжруулалт хийхэд орчин үеийн үнэлгээний арга болох CIPP (context-Input-Process-Product) загварт суурилсан аргачлалыг сонгосон байна.

Анхаарах асуудал:

- Үнэлгээний CIPP (context-Input-Process-Product) аргыг хэрэгжүүлэх, практикт нэвтрүүлэх
- Хөтөлбөрт ehealth програм дээр ажиллах талаар сургалтын төлөвлөгөөнд тодорхой цаг оруулах юм уу эсвэл дадлагын бааз газруудын сургагч багшийг дагалдуулан сургах
- Эмчлүүлэгчид эмийн хэрэглээний талаар зөвлөгөө өгөх, эмийн тооцоолол хийх (дусал шингэний урсах хурд, эмийн тун тооцох...гм) чадварыг нэмэгдүүлэх боломжийг судлах, гарц хайх

Зөвлөмж:

- Мэргэжлийн онцлогоос шалтгаалан оролцогч талуудын оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх. (Багш, оюутан, төгсөгч, ажил олгогч + **эмчлүүлэгч**). Тэдний санал хүсэлт, зөвлөмжийг сонсох

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг боловсруулахад БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын мэргэжлийн чиглэлд таигдах нийтлэг шаардлага”, Төрөөс эрүүл

мэндийн талаар баримтлах -2024, Монгол Улсын стандарт, Сувилахуй MNS5323-129:2012, ДЭМБ-ын Сувилахуй болон Эх барихуйн тусламж үйлчилгээний стратеги (2021-2025) зэргийг хөтөлбөрийн төлөвлөлтөд ашиглаж, Монгол Улсад мөрдөгдөж буй эрхзүйн баримт бичгийн шаардлагад нийцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

- Төгсөгчийн эзэмших цогц чадамж гаргасан
- Хичээлийн хөтөлбөрүүдэд тухайн хичээлээр олж авах мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулалт, хяналт, үнэлгээний чиглэлээр олон үе шаттай ажлууд хийж байна. Үүнд: Сургуулийн хэмжээнд 8 ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаагийн нэг нь хөтөлбөрийн хөгжлийн баг.
- Сувилахуйн мэргэжлийн хөтөлбөрийн агуулгыг үнэлэх ажлын хэсгийг АШУҮИС-ийн 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/199 дугаар тушаалаар 10 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
- Сувилахуйн хөтөлбөрийн мэргэжил ба тэнхим тус бүрт 3-4 хүний бүрэлдэхүүнтэй 6 үндсэн үнэлгээний баг ажиллаж байна.
- Хөтөлбөрийн дэд хороог байгуулан, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд хэр хангагдаж буйд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулж санал, зөвлөмж гаргадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үнэлгээний баг 73 хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийж 37 жижиг үл тохирол илрүүлж, засч залруулж, шинэчлэл, сайжруулалт хийсэн. (хичээлийн агуулгын давхцал, цогц чадамжтай нийцсэн байдал, босоо, хэвтээ тэнхлэгийн уялдаа холбоо гм)
- Үйл ажиллагааны зураглал (ISO-9001 замын зураглал 30) төлөвлөлтийг тодорхой ойлгомжтой, дэс дараалалтай байсан.
- Оюутны амжилтын хөтөч гаргасан

Анхаарах асуудал:

- Суралцахуйн үр дүнгийн матриц (нэгдсэн)-ыг боловсронгуй, тодорхой болгох
- Цогц чадамжийн зарим үзүүлэлтийг эргэж харах. Тухайлбал мэргэжилтний эзэмших ёстой чадвар дээр хаалга тогшиж орох гэх мэт орох эсэх.
- Мөн суралцагсдыг хэтэрхий их мэдээллээр дарахаас зайлсхийх
- Сургалтын үр дүнд зөвхөн чадвараар олгох ажилбараас гадна сувилахуйн онол, онолчдын категори, хүн рүү чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, ачаалал даах чадвар, зөөлөн ур чадвар суулгах
- Оюутны техник сэтгэлгээ, техниктэй ажиллах чадвар дээр анхаарах

Зөвлөмж:

- Цогц чадамжийг эрэмбэлэх, заавал эзэмшвэл зохих чадамжийг гаргах, хэрэгжүүлэх
- Сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт аргыг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх

Дүгнэлт: Хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгцээ шаардлага, зорилго, баримт бичиг нь Дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалт, мэргэжлийн стандарт, стратеги, боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн сургалтын хөтөлбөрт тавигдах шалгуур шаардлага зэрэг хууль эрх зүйн актуудыг бүрэн хангасан.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- 2016 оноос ISO 9001:2015 байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн. ISO 9001:2015 стандартын үйл явцын зураглалын дагуу сургалтын агуулгаа дотоод аудитын баг хөтөлбөрийн дэд хорооноос хөндлөнгийн үнэлгээг 3-5 жилд 1 удаа хийж сайжруулдаг. Багш нар хичээлийн хөтөлбөрийг жил бүр 30 хүртэлх хувиар тогтмол сайжруулан хэрэгжүүлдэг.
- Мэргэжилтний цогц чадамжийг боловсруулан гарын авлага хэлбэрээр гарган багш, суралцагч нартаа мэдээлэл хүргэдэг. Мэргэжлийн чиглэлээр 63 төрлийн мэдлэг, 174 төрлийн ур чадвар, 62 хандлага төлөвшүүлэхээр мэргэжлийн хөтөлбөрийн үр дүнгээ тодорхойлон хамаарлыг хичээлийн хөтөлбөрөөр тооцож гарган босоо болон хөндлөн залгамж холбоог сайжруулан, агуулгын давхцал болон үл нийцлийг сайжруулан ажилладаг. Хичээлийн үр дүн (CLO)-г хичээлийн хөтөлбөр бүрт тусган, хөтөлбөрөөр олгох цогц чадамж(PLO)-ийн уялдаа холбоог тодорхойлон хэрэгжүүлдэг. Хөтөлбөрийн үр дүн болон цогц чадамжийг Олон улсын боловсролын салбарт хэрэглэгддэг загвар бүхий CIPP загвараар үнэлэн сайжруулдаг.
- Хичээлийн хөтөлбөрийг хичээлийн нэр, индекс, хичээлийн агуулгын багтаамж, хичээлийн зорилго, хичээлийн төгсгөлд хүрэх үр дүн, хичээлийн төгсгөлд хүрэх цогц чадамж, хичээлийн өмнө судалсан байвал зохих хичээлийн нэр индексийн босоо, хэвтээ тэнхлэгээр, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөг онол, дадлага, бататгал хичээл, бие даалтаар тодорхойлон цагийг нарийвчлан тусгадаг. Мөн хичээлийн үндсэн агуулгыг лекц семинараар тодорхойлон хичээлийн бэлтгэл, хичээлийн арга, үнэлгээг нарийн тусган хэрэгжүүлдэг.
- Төгсөх дамжааны оюутнуудаас хөтөлбөрийн үр дүн болох цогц чадамжийн сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг тооцоход “**сайн болон маш сайн**” үзүүлэлтээр багшийн заах арга зүй 77.5 хувь, хичээлийн сэдэв, хоорондын уялдаа холбоо үзүүлэлт 77.6 хувьтай, хичээлийн хуваарь 72.1 хувьтай байна. Цогц чадамжаар төгсөх дамжааны оюутнуудаас жилд 1 удаа судалгаа авдаг бөгөөд хичээл бүрийн үнэлгээг улирал тутамд хийдэг. Үүнээс гадна тасагт хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүсээс судалгааг авч хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагадаа тусгахаар ажиллаж эхний ээлжийн судалгааг авсан байна.
- Хөтөлбөрийг багш, тэнхим, хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын хэсэг, хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн ерөнхий хороо гэсэн дарааллаар хэлэлцүүлэн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулдаг. Хөтөлбөрийн ерөнхий хорооноос гарсан шийдвэрийн дагуу хөтөлбөрийн дэд хороо болон хөтөлбөрийн хөгжил хариуцсан алба тогтмол хуралдан хөтөлбөрийн сайжруулалтыг хийдэг.
- АШУУИС-ийн Дадлага нэгдсэн журам 2015 оны сарын 15-ний өдрийн А/144 хавсралтын дагуу хэрэгжүүлдэг. Нийтлэг үндэслэл, дадлагын удирдлага, ерөнхий

зохион байгуулалт, дадлагын явцын хяналт, үнэлгээ, дадлага удирдах багшийн үүрэг, хариуцлага зэргийн тусган удирдамжийг боловсруулан хэрэгжүүлдэг. Жил бүр дадлагын тушаал гарч гэрээт эмнэлгүүддээ оюутны тоо, дадлагын цаг, эхлэх, дуусах хугацааг тодорхойлон хуваарийн дагуу зохион байгуулж, үнэлгээг мэргэжлийн багш нар хуваарийн дагуу ертөөчилсөн гардан шалгалтаар үр дүнг тооцон хамгаалуулдаг. Дадлага болон шууд гэрээт 44 байгууллагатай хамтран ажилладаг.

- Багшийг сонгон суралцах боломжийн талаар багш нараас судалгаа авч боломжийг тооцон гаргасан. Мөн биеийн тамирын хичээлийг бие хамгаалах, уулын алхалт, иого, бүжиг гэсэн төрлүүдээс сонгон хичээллэдэг. Сонголтоо sw.xcloud.mn программаар сонгон хэрэгжүүлдэг.
- 4 жилийн хугацаанд суралцах сургалтын төлөвлөгөөг оюутны цахим программд байршуулдаг. Сургалтын төлөвлөгөөний оюутны цагийн ачааллыг тэнхимээс саналыг өгч нэг өдрийн ачааллыг 4 (контакт цаг), 7 хоногийн ачаалал 20 цагаас ихгүй байхаар тусгадаг. Оюутны төлөөлөлтэй уулзах явцад сургалтын ачаалал боломжийн байдаг гэсэн хариултыг өгч байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- 2016 оноос ISO 9001:2015 байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн.
- Багшийг сонгон суралцах боломжийн талаар багш нараас судалгаа авч боломжийг тооцон гаргасан. Мөн биеийн тамирын хичээлийг төрлөөр нь сонгодог зэрэг нь онцлог байна.
- Дамжаа бүрт дадлага хийх боломжоор ханган дадлагажуулдаг.
- Оюутны цагийн ачааллыг тэнхимээс саналыг өгч нэг өдрийн ачааллыг 4 (контакт цаг), 7 хоногийн ачаалал 20 цагаас ихгүй байхаар тусгадаг.

Анхаарах асуудал:

- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад хэрхэн тусгасан талаар тайланд бага тусгагдсан
- Хичээл сонгох боломж судалгааны түвшинд байгаа бөгөөд хичээл сонголтын хувьд хязгаарлагдмал байгааг анхаарах (4 жилийн хугацаанд 20 хичээлээс 4 хичээлийг сонгодог)
- Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн сургалтын төлөвлөгөөнд эзлэх хувь A/174 тоот тушаалын эзлэх хувиас ялгаатай.
- Ажил олгогчдын зүгээс сувилахуйн 5 шатлалыг практикт хэрэгжүүлэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх мөн яаралтай тусламжийг хамтран үзүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах
- Оюутнуудын зүгээс англи хэлнээс гадна бусад хэлнээс сонгон суралцах боломжоор хангах
- Багш нарын зүгээс эмнэлзүйн дадлагыг урсах графикаар тасралтгүй хийлгэх боломжийг судлах
- Төгсөгчдийн зүгээс шинжилгээний хариу унших, тайлбарлах чадвар эзэмшүүлэх зорилгоор хичээлийн төлөвлөгөөнд нэмэлтээр оруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүн болон цогц чадамжийн талаар суралцагч, төгсөгч, ажил олгогч нараас санал асуулга, судалгааг авч тусгадаг байх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУУИС-ийн захирлын 2015 оны А/144 тоот тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “АШУУИС-ийн Сургалтын технологи чанарын хяналтын үлгэрчилсэн журам”-ыг мөрдөн мэргэжлийн хөтөлбөрийн арга зүйг сургалтын SPICES дараах загвараар хэрэгжүүлдэг. Үүнд:
 - Student centered-оюутан төвтэй
 - Problem based-асуудалд суурилсан
 - Integrated-нэгдмэл
 - Community oriented-нийгэмд чиглэсэн
 - Elected-сонголттой
 - Systematic-системтэй аргыг ашиглан хэрэгжүүлдэг.
- Хичээлийн хөтөлбөрт онол, дадлага, бататгал хичээл, бие даалтын арга зүйг тусган үйл явцын зураглалын дагуу зохион байгуулдаг.
- Багш нарын хамгийн түгээмэл хэрэглэдэг 24 аргаас хамгийн олон давтамж бүхий аргуудад ярилцах арга, тохиолдолд суурилсан арга (дадлага), гардан хийх арга, жижиг бүлгээр ажиллах арга, асуудал дэвшүүлэх, цахимд суурилсан арга (семинар) эдгээр аргуудыг 256 удаагийн буюу хамгийн өндөр давтамжтай ашигладаг. Үүнээс дадлага болон семинарын хичээлд тохиолдолд суурилсан аргыг, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдэд гардан хийх аргыг өргөн хэрэглэдэг.
- Сувилахуйн тусламжийг хосолсон системээр үзүүлэх арга зүйг ашигладаг онцлогтой
- Клиник сургалтын үйл ажиллагааг оюутанд ойртуулах, багш нар гэрээний дагуу бааз эмнэлгүүд дээр харьяалагдан бодит чадварыг олгоход зөвлөн тусалдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн тусламжийг хосолсон системээр арга зүйг сургалтанд ашигладаг.

Анхаарах асуудал:

- Сургалтанд 7 төрлийн арга зүйг 256 удаагийн давтамжтай мөн багш нарын хичээлд ашиглаж буй арга зүй нь 2-3 төрөл байгаа нь сургалт явуулж буй арга зүйн төрөл, хэлбэр цөөн байгааг анхаарах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 4-р бүлгийн “Үнэлгээний аргачлал”-аар явцын болон улирлын шалгалтын үнэлгээг зохион байгуулдаг. Мөн явцын болон улирлын шалгалтын үнэлгээг

“Шалгалтын арга хэлбэрүүд I,II” гарын авлагыг боловсруулан гаргаж багш, суралцагчдадаа нээлттэй ашиглах боломжоор хангадаг. Мөн гардан үйлдлийн хичээлүүд дээр үнэлгээний 360 арга буюу оюутан өөрийгөө үнэлэх, ижил суралцагчаар хөндлөнгөөс үнэлэх, багшийн үнэлгээний аргыг танхимын сургалтын явцад тогтмол ашиглан хэрэгжүүлдэг онцлогтой.

- 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 7-р бүлгийн заалтыг үндэслэн төгсөлтийн шалгалтыг онол болон өртөөчилсөн гардан шалгалтаар зохион байгуулдаг. Үүнээс гадна онолын шалгалтыг цахимаар зохион байгуулдаг бөгөөд нийт 25 хичээлийн агуулга бүхий 2500 орчим цахим тестийн сангаас санамсаргүй сонголтоор авч жил бүр сорилын сандаа анализ хийж сайжруулалт хийдэг. Төгсөлтийн онолын шалгалтыг мэдлэг үнэлэх сорилын 4 хэлбэрээр А,В, Е,К (40:40:10:10) зохистой харьцаагаар, санамсаргүй байдлаар сонгон авч анализыг багш, мэргэжлийн тэнхим хийж, сургалтын алба хөндлөнгөөс хянадаг. Мөн сорилын эмхэтгэлийг боловсруулан жил бүр 20-30 хувьд баяжуулалт хийдэг.
- Төгсөлтийн гардан шалгалтыг өртөөчилсөн байдлаар зохион байгуулж, **“OSCE болон OSPE гүйцэтгэлийг үнэлэх шалгарсан арга”** гарын авлагыг боловсруулан багш, оюутнууд ашигладаг. Төгсөлтийн шалгалтын мэргэжлийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар шалгалтын зохион байгуулалт, үйл ажиллагаа, шалгалтын үр дүнд үнэлгээг хийж хэлэлцдэг.
- Багш нар цахим сорилд Moodle программын тусламжтайгаар анализ хийн, сайжруулдаг.
- Тэнхим бүр хичээл бүрийн амжилт чанарыг тооцон гаргаж, тэнхимийн эрхлэгч баталгаажуулан, хөндлөнгөөс ТӨСБЗГ-ын арга зүйч нар үнэлгээ хийж үнэлгээний ил тод байдлыг хангадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн шалгалтанд онолын мэдлэгийг 4 хэлбэрийн сорилоор үнэлэн сорилын эмхэтгэлийг жил бүр 20-30%-иар шинэчлэн боловсруулдаг.
- Эмнэлзүйн сургалтанд Миллерийн үнэлгээний аргыг нэвтрүүлэн оюутнаа 5 түвшинд үнэлдэг.
- Мэргэжлийн суурь хичээлүүдэд “360 хэм”-ийн үнэлгээний аргыг ашигладаг. Мэргэжлийн суурь хичээлүүдэд Moodle программыг өргөн хэрэглэдэг.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин хөтөлбөрийн хэсэгт нотлох баримт нийт 30 жагсаалт байна. Үүнд: хөрөнгийн гэрчилгээ, эзэмшил газрын байршилын кадастрын зураг, сургуулийн план зургууд давхар бүрээр, оюутны хувцасны локерын зураг, анги танхимын

үзүүлэлтүүд, цахим сургалт хийх орчин, оюутанд зориулсан орчин, ур чадварын төвийн үйл ажиллагааны хангамж, хүрэлцээ, орчинг тусгасан жагсаалтууд, номын сангийн ажиллах журам, номын жагсаалт эдгээрийн үйл ажиллагааны тайлангууд байна.

- Сургуулийн эдлэн газрын хэмжээ 8976 м2 байна. (МУ-ын төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ №000434960 2014 он)
- Сургалтын үйл ажиллагаа явуулах орчины болон технологийн нөхцөл нь “Дээд боловсролын байгууллага байгуулахад тавигдах нийтлэг шаардлага” норм нормативыг хангасан байна. Үүнд: 7 тэнхимд нийт сургалтын өрөө- 31, хичээлийн өрөө-19, лекц танхим-4, номын сан-5, лабортори-3, хагалгааны өрөө-2, компьютерийн өрөө-1, төрөлжсөн сувилахуйн өрөө-7, гадаад хэлний өрөө-1, интернет цахим сургалтын өрөөнүүд 3 тус тус байна. Үйлчилгээнд зориулсан нийт-12 өрөө, спорт заал, цайны газар, хувцас солих өрөө, оюутны эрүүл мэндийг дэмжих төв, өлгүүр, ариун цэврийн өрөөнүүд зэрэг байна.
- Хичээлийн байрны ашигтай талбай 5201 м2, хичээлийн байрны суудлын тоо 981, нэг оюутны ашигтай талбай 7,4 м2, ариун цэврийн өрөөнд нэг суултуурт 20-25, нэг угаалтуурт 30-35 оюутан ноогдохоор тус тус байршуулсан байна.
- Сургалтын орчинд барилгын болон тоног төхөөрөмжийн шинэчлэлүүдийг хийсэн байна. Үүнд: спорт заал, ариун цэврийн өрөө, цонх, орох гарах хаалга, коридорт 2018-2020 онд, сургуулийн гаднах машины талбайг 2018-2022 онд, оюутны хувцас солих өрөө, хувцас солих локер 512 ширхэг баршуулсан, зарим оюутны сургалтын өрөө зэрэгт жил бүр 2020, 2021 онуудад урсгал засвар шинэчлэл хийж ирсэн байна. (тайланд тусгасан байна)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуульд оюутны сурах орчин барилгын засвар, тоног төхөөрөмж сайтай байна.

Анхаарах асуудал:

- Стандартаар нэг багшид ноогдох талбай 4 м2, одоогийн байдал 2 м2 байгаа нь цаашид нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт судалгааны программ хангамж интернет орчинд magicnet-LAN, KEWIKO-wifi, Skynet-wifi (оюутанд) зэрэг wifi ашиглаж байна, мөн номын сангийн сүлжээнд Kona, багш болон оюутнуудад e-erdem сургалтын платформ, e-learning зэргийг бүрэн ашиглаж байна. Сургалт судалгааны төвийн компьютерт SPSS, STATA, Endnote зэрэг программ хагамжийг ашиглан судлаач багш, оюутан судлаачид судалгаа шинжилгээний ажил, үр дүн боловсруулж байна. Мөн “Нээлттэй их сургууль” байх стратеги зорилтын хүрээнд их сургуулийн удирдлагын мэдээллийн систем UNIMIS (Cloud university)-ийг нэвтрүүлж үүнд админы, сургалтын, багшийн, оюутны, эцэг эхийн программуудыг ашиглаж байна. (АШУҮИС-ийн захирлын А/55-р тушаал)
- Сургалтын орчинд проектор, өсгөгч, микрофон, LED ТВ, аудио видео ситем, самбар зэргээр ханган ажиллаж байгаа нь дээд боловсролын байгууллагад тавигдах орчны

- стандартыг бүрэн хангасан байна. Цахим хичээлийг чанарын өндөр түвшинд явуулах орчин үеийн тоног төхөөрөмж бүхий контент болон аудио“ бүхий 3 өрөө төвтэй болсон.
- Ур чадварын хичээлийн нийт 9 өрөөнд эмнэлгийн тоног төхөөрөмж, дуураймал орчин, бүтэн биеийн муляж 5, хэсэгчилсэн муляж 20 гаран, дуураймал төрөгч эх (улсад 1ш байгаа), багж хэрэгслэл, нэг удаагийн хэрэгслэл, ширээ сандал зэргээр хангаж ажиллаж байна. (тоо баримтыг тайланд тусгасан байна) Дадлагын өрөөний багаж тоног төхөөрөмжинд ариутгал цэвэрлэгээг журмын дагуу хийж байна.
 - Сувилахуйн дадлага хичээл явуулах бааз гэрээт эмнэлгүүдтэй байна.
 - Оюутны гардан ажилбарт нэг удаагийн хэрэгслэл материалыг ашиглаж байна.
 - Оюутны байранд СС-иас нийт 300 оюутан амьдарч байна.
 - Эмнэлгийн хог хаядал хаях тушаал, журмын дагуу “Элемент” ХХК-тай жил бүр гэрээ хийж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт судалгааны программ хангамж интернет орчин маш сайн хөгжсөн байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сан нь нийт 59,02 м2 талбайд, 2 уншлагын танхим, 1 цахим уншлагын танхим, 23 суурин компьютер, 3 номын санчтай ажиллаж байна. Номын сан MNS 5742:2019 –ийг баримтлан ажиллаж байгаа ба орчин, гэрэлтүүлэг, чийгшил, дуу чимээ нь стандартад заасны дагуу байна. Номын сангийн гэрэлтүүлэг 200 люкс, уншилгын танхимын гэрэлтүүлэг байгалийн болон хиймэл гэрэлтүүлэг хосолсон, чийгшил 55+-5, өрөө тасалгааны дулаан +20+-1,5, сан хөмрөг хадгалах байр +18+-2, номын сангийн агаар солилцоо нэг цаг тутамд хийгдэх зэргээр стандарт хангасан байна.
- Багш суралцагчдын сургалтын үйл ажиллагаанд хэрэгцээт ном нийт 23,073 номтой үүнээс монгол 20,060, орос 1,186, англи 1827 байна.
- 2015 оноос KoHa программ ашиглаж, номын сангийн бүх номууд бүртгэгдсэн байна. Үүнд library.mnnums.edu.mn:8080 хаягаар орж хайлт хийж байна.
- Номын сангийн шинэчлэлийг жил бүр хийж тоо болон хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна. 2021 онд 4,358,974 төгрөгний 61 ширхэг номыг фондод авсан байна. Мөн олон улсын сэтгүүлүүдийг захиалж байна, 2021 онд АШУҮИС-иас HINARI ашиглах 1500\$ төлбөр төлсөн ба нийт багш, судлаачид 22036 удаа хандсан байна. Hinari-д 8900 орчим хурлын материал, илтгэл өгүүлэл, 21000 орчим сэтгүүл, 70000 орчим номтой байна.
- 2021 оноос ном ариутгагч ашиглаж халдвар хамгааллын журмыг баримталж байна. Ном ариутгагч нь нэг удаадаа 80-100 ширхэг ном ариутгах хүчин чадалтай.
- Номын сангийн 2017-2021 онд нэмэгдсэн номын тоо, номын сангаар үйлчлүүлсэн оюутны тоо зэрэгт сэтгэл ханамжийн судалгааг хийсэн. Судалгаанд нэмэгдсэн номын тоо 2017 онд 411, 2018 онд 303, 2019 онд 230, 2020 онд 150, 2021 онд 543, номын сангаар үйлчлүүлсэн оюутны тоо 2017 онд 22,414, 2018 онд 27,846, 2019 онд 27,090, 2020 онд 9,481, 2021 онд 9,242 тус тус нэмэгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Коһа программ ашиглаж байна, мөн ном ариутгагчийг 2021 оноос эхлэн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Уншилгын танхимд акустик ханатай болгох. (уншлагын танхимд чимээ ихтэй байна)

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сувилахуйн сургуулийн захирлын тушаалаар (2020.11.10 -ны А/18, 2021.11.11 -ны А/50) сургалтын хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын хэсэг жил бүр ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Хөтөлбөр боловсруулах, сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шинэчлэх, сайжруулахтай холбоотой хөтөлбөрийн хорооны бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө тодорхой
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх дүрэм журмын жагсаалтыг тодорхой гаргасан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хичээлийн агуулгын сайжруулалтыг жил бүр хийдэг хэдий ч сүүлийн 5 жилийн дунджаар харахад ямар байгаа, ахиц дэвшил гарсан эсэх талаар харьцуулсан судалгаа хомс байгааг анхаарах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нар 2017-2021 онуудад гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран 16 төрлийн төсөлт ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- Гадаадын урт болон богино хугацааны мэргэжил дээшлүүлэх болон багш солилцоо хөтөлбөрийг 12 удаа зохион байгуулж нийт 14 багш оролцсон байна.
- Оюутан солилцоог 5 удаа зохион байгуулж мэргэжлийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөгжлийн бодлого, оюутнуудын амьдралын хэв маягийн талаар илтгэл хэлэлцүүлэн, туршлага солилцохоос гадна орон орны ёс заншил, соёлыг сурталчилан таниулсан байна.

- Нийгэмд чиглэсэн үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал: өөрийн сургуулийн болон бусад сургуулийн мэргэжил нэгт багш нарт чиглэсэн сургалт -4, төгсөгчдөд чиглэсэн сургалт -14, ард иргэдэд чиглэсэн сургалт-12 тус тус захиалгаар болон өөрсдийн санаачлагаар хийж гүйцэтгэсэн байна. Мөн ковид-19 цар тахлын хүнд үед төв сургуулийн эмнэлэгтэй хамтран ажиллаж, ковид-19 ийн үед хийгдэх эмийн бус эмчилгээний зөвлөмж, сувилахуйн тусламжийн зөвлөгөө, албан байгууллагуудад мөрдөх зураглал зэргийг боловсруулсан байна.
- Төгсөгчийн холбооны бодлого, төлөвлөлттэй. Тус холбоогоор дамжуулан багш шавийн уулзалтыг 3 жил тутамд, мэргэжлийн үйл ажиллагаагаар зөвлөн туслах, мөн төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулдаг. Төгсөгчдийн давтан сургалтыг 29 чиглэлээр зохион байгуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар нийгмийн хариуцлагын хүрээнд төгсөгчид, ард иргэд, төрийн болон төрийн бус өмчит сувилахуйн сургуулийн багш нарыг чадвахижуулах зорилгоор сургалт, семинар болон мэргэжлийн үйл ажиллагааг санаачилгаараа болон захиалгаар үйлчилдэг.
- Багшийг чадваржуулах (зохион байгуулах, удирдах, багшлах ур чадварыг нэмэгдүүлэх) зорилгоор гадаадын байгууллагатай хамтран ажилладаг байна. Тухайлбал: Мөн JICA олон улсын байгууллагаас зохион байгуулдаг эмнэлзүйн чиглүүлэгч-3, сургагч-3 багшийг тус тус хамруулсан байна.

Зөвлөмж:

- Хамтарсан хөтөлбөр болон багш, оюутан солилцоог дотооддоо зохион байгуулах, туршлага солилцох, цөм хөтөлбөрийг боловсруулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэл, өөрчлөлтөд нилээдгүй хөрөнгө, мөнгө зарцуулсан байна. Тухайлбал эмнэлзүйн лабораторид 83 нэр төрлийн 343 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, цахим сургалтын өрөө, бусад мэргэшүүлэх өрөө кабинет, лабораторийг тохижуулж, сургалтад зориулж муляж, багаж тоног төхөөрөмжөөр сургалтын орчинг өөрийн хөрөнгөөр болон гадны байгууллагын дэмжлэгтэйгээр сайжруулсан байна.
- Хөтөлбөрийн орлого, зарлагыг гаргасан байна.
- Эрдэм шинжилгээний зардал 2020-2021 оныг өмнөх онтой харьцуулахад 56.9% өссөн дүнтэй харагдаж буй боловч 2017-2018 оноос хойш сүүлийн 5 жилийн дунджаар -9.9 иар буурсан байна.
- Ном сурах бичгийн зардал 2020-2021 оныг өмнөх онтой харьцуулахад 50% өссөн дүнтэй харагдаж буй боловч 2017-2018 оноос хойш сүүлийн 5 жилийн дунджаар 17 хувиар буурсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрөөс олох орлого, зарлагын бүртгэл нь санхүү нягтлан бодох бүртгэлийн зүйл ангиар тусган эмх цэгцтэй, системчлэгдсэн байна
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэл өөрчлөлтөд зарцуулсан төсөв жилээс жилд нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Нэг оюутанд ногдох дундаж зардал сүүлийн 5 жилийн дунджаар 0.9%-иар буурсан байна.
- Оюутны дундаж тоо сүүлийн 5 жилийн дунджаар -2.8%-иар буурсан

Зөвлөмж:

- Бусад орлогын эх үүсвэрийг эрэлхийх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын албатай. Үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдыг гадаадад дадлагажигчаар 3 жил ажиллуулж, мэргэжлээрээ 2 жил суралцуулдаг.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэхдээ төв сургуулийн вэб сайтаас гадна оюутанд чиглэсэн мэдээллийг 2 цахим мэдээллийн систем ([http:// elearning.mnums.edu.mn](http://elearning.mnums.edu.mn); e-erdem.mn), сургуулийн албан ёсны фейсбүүк хуудас, мэргэжлийн хичээлийн блоггоор дамжуулан хүргэдэг.
- Багшид мөн вэб сайтаас гадна фейсбүүк хуудас болон тэнхим тус бүрийн 9 холбоосоор дамжуулан хүргэж, үйл ажиллагаа явуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын процесс ялангуяа багшийн бүх процесс цахимжсан байна.

Зөвлөмж:

- Дараа дараагийн тайлан бичихдээ өмнөх 5 жилтэй харьцуулсан байдлаар, ахиц дэвшлийг тодоор харуулж, өөрсдийн оюун дүгнэлтийг хийх байдлаар бичих.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн үйл ажиллагаа АШУҮИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам” дагуу цахимаар нээлттэй зохион байгуулдаг. Журмыг шинэчлэн батлаж элсэгчдэд Хими, биологи хичээлийн сууриар хязгаарладаг байсныг өөрчлөн математик болон англи хэл хичээлийг нэмж оруулан 4 төрлийн хичээлийн өндөр оноогоор элсэх боломж олгосон. Үүнтэй холбоотой элсэгчдийн суурь онооны дундаж сүүлийн жилд 545-550 болж өссөн. Сүүлийн үед төрөөс бодлогоор сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлснээр элсэгчдийн чанар, тоо нэмэгдсэн. Элсэлттэй холбоотой мэдээллийг цахим сүлжээ, веб сайтууддаа байршуулдаг.
- Шинээр элсэгчдэд “Удиртгал” хичээлийг үндсэн хуваарьт хичээл эхлэхээс өмнө 5 хоногийн сургалтыг албан ёсны хуваарийн дагуу зохион байгуулан сургууль болон мэргэжлийн үнэ цэнэ, биеэ авч явах соёл, номын сангийн үйлчилгээ, дүрэм журам, цахим сургалт, веб ашиглалт, суралцах хугацаанд үүсэх асуудлуудаар сургуулийн удирдлага, профессорууд, багш болон арга зүйч нар зөвлөн тусалж хичээл ордог. Өдөр өдрөөр хичээлийн төлөвлөлтийг нарийн тусган зохион байгуулдаг. Өмнө нь танхимаар явдаг байсан бол цар тахлаас хамааран сүүлийн 2 жилд цахимаар зохион байгуулж байна.
- Сувилахуйн сургуулийн оюутны хөтөчийг
 - ✓ **Бүтэц бүрэлдэхүүн**
 - ✓ **Сургалтын үйл явц**
 - ✓ **Суралцагчийн дэмжих үйлчилгээ**
 - ✓ **Байршлын хөтөч** гэсэн 4 чиглэлээр гарын авлага боловсруулан хүргэдэг мөн e-erdem.mn сайтанд цахим хэрбэрээр байршуулан суралцах хугацааны бүх мэдээ, мэдээллээр хангадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийг Төгсөлтийн өмнөх сургалтанд оюутан элсүүлэх журмын дагуу цахимаар нээлттэй байдлаар зохион байгуулдаг.
- Шинээр элсэгчдэд “Удиртгал” хичээлийг зохион байгуулан сургууль болон мэргэжлийн үнэ цэнэ, биеэ авч явах соёл, номын сангийн үйлчилгээ, дүрэм журам, цахим сургалт, веб ашиглалт, суралцах хугацаанд үүсэх асуудлуудаар сургуулийн удирдлага, профессорууд, багш болон арга зүйч нар зөвлөн тусалдаг.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн хэмжээнд “**Эрүүл оршихуй**” хөтөлбөрийг Ерөнхий эрдмийн тэнхимийн хурал, тэнхимийн эрхлэгчдийн хурал (2021.06.04 өдрийн 20 тоот, 6 сарын 10-ны 21 тоот хурал), Оюутны хөгжил хариуцсан ажлын хэсгийн хурал, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж I-IV дамжаанд хамрагдах боломжтой бөгөөд “Оюутны бие бялдар, эрүүл аж төрөх ёс, гоо зүй, сэтгэл зүй, хувь хүний хөгжил зэргийг өв тэгш төлөвшүүлэн оюутан залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд туслах зорилготой” дараах 4 чиглэлээр
 1. Оюутны эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа
 2. Оюутны эрүүл сэтгэл зүйд чиглэсэн үйл ажиллагаа
 3. Оюутны эрүүл бие бялдарыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
 4. Гоо зүй, хувь хүний хөгжилд чиглэлийн дагуу нийт 40 ажлыг тогтмол зохион байгуулж, суралцагчдаа хөгжүүлэх болон зөвлөн тусалдаг. Хамрагдах боломжийг дамжаа бүрээр тодорхойлон гаргасан бөгөөд энэ нь сургалтын үйл ажиллагаанд ачаалал өгөхгүй байх жигд оролцох боломжоор хангадаг. Жишээлбэл оюутны эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа ажлын хүрээнд “Оюутан ээж” үйл ажиллагааг жилийн турш зохион байгуулан уулзалт, үзлэг, зөвлөгөөг өгдөг.
- АШУҮС-ийн хэмжээнд “Оюутан хөгжил” хөтөлбөрийг 2021 оны 09 сарын 17 өдрийн А/187 тушаалаар батлан дараах 4 дэд хөтөлбөрийн хүрээнд суралцагчдаа олон талаар хөгжих боломж олгодог. Үүнд:
 - ✓ Эх оронч оюутан
 - ✓ Үлгэрлэгч оюутан
 - ✓ Эрүүл авъяаслаг оюутан
 - ✓ Хөдөлмөрч оюутан удирдамжийг боловсруулан, ажлын төлөвлөгөө, календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг. Хэрэгжилтийн үр дүнгийн өдөрлөгийг зохион байгуулж шалгаруулалт хийдэг.
- 2021.10.08 өдрийн А/26 тоот Анги даасан зөвлөх багшаар томилон ажиллуулах тушаалаар Зөвлөх багшийн үүрэг, хийх ажил, тооцох үр дүн хавсралтын дагуу үүрэг, хийх ажил, үр дүнг тооцон багшийн Б цагийн хэрэгжилтэнд тооцдог. Эрүүл оршихуй дэд хөтөлбөртэй уялдан ангийн багшийн оролцоо, дамжаа бүрт хийх ажлыг тодорхой тусгаж өгсөн байдгаараа онцлог давуу талтай.
- Орон нутгийн оюутны тоо олон, эмнэлгийн тусламж үзүүлэх чиглэлээр Сувилахуйн сургуулийн хэмжээнд 2021 оны 10 сарын 22 өдрийн А/28 тоот тушаалаар Оюутны эрүүл мэндийг дэмжих, төв байгуулах тухай тушаалын дагуу “**Оюутны эрүүл мэндийг дэмжих төв**”-ийн үйл ажиллагааг эхлүүлэн дотоод дүрэм журмыг батлан хэрэгжүүлдэг. Энэхүү төвийн үйл ажиллагаа нь Эрүүл оршихуй хөтөлбөртэйгөө уялдан төлөвлөгөө, ажиллах бүрэлдэхүүнийг томилон үйл ажиллагааг явуулдаг. Багш нарын мэргэжлийн үйл ажиллагааг давхар дэмжих, Б цагаар тооцон урамшуулдаг. Охид эмэгтэйчүүдийн үзлэг, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө, дотрын эмч, хүүхдийн үзлэг, оюутан ээж, мэс заслын эмчийн үзлэг, сувилахуйн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөөг мэргэжлийн багш нар үзүүлж оюутнаа дэмжин ажилладаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдсэн тайланг гаргаж танилцуулдаг. Одоогоор нийт давхардсан тоогоор 1939 оюутанд үйлчилгээ үзүүлсэн байна.
- Оюутны гоо зүй, хувь хүний хөгжлийг төлөвшүүлэх зорилготой багш, оюутныхаа бүтээлийг танилцуулах, нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “**Оюуны галерей**”

байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн. Үүний хүрээнд гар зургийн уралдааныг зохион байгуулж бүтээлээр үзэсгэлэн гаргасан, мөн шүлгийн ертөнц үзэсгэлэн, оюутнуудын гараар хийсэн бүтээлийг борлуулах боломжоор ханган миний бүтээл үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаа нь оюутнуудыг дэмжих хөтөлбөрүүдтэйгээ уялддаг.

- Сувилахуйн сургуулийн хэмжээнд оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол зохион байгуулдаг бөгөөд удирдамжийг жил бүр гарган зохион байгуулан шалгарсан бүтээлийг АШУҮИС-ийн хэмжээнд хэлэлцүүлэн бүтээлийн эмхэтгэлийг гаргадаг. Үүнээс гадна Nursing and IPT клубийн хүрээнд “Оюунлаг залуус” оюутны эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж, ирүүлсэн бүтээлээр эмхэтгэл гарган бүтээлийг цахимд байршуулж нийтийн хүртээл болгодог. Эрдэм шинжилгээний чиглэлээр амжилт гаргасан тохиолдолд шилдэг оюутан шалгаруулж урамшуулдаг. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор төсвийг нэмэгдүүлсэн.
- Оюутны төсөл бичих чадавхжуулах зорилгоор 25 ментор багшийг бэлтгэсэн. Эдгээр багш нараа түшиглэн төслийн багаа мэргэжил, дамжаа харгалзахгүйгээр холимог байдлаар бүрдүүлэн, багууд багшийнхаа удирдлаганд төслөө бичдэг. Төслийн үр дүнг жилд 1 удаа хэлэлцүүлэн шилдэг 5 төслийг шалгаруулан урамшуулдаг. Төслийн шалгаруулалтад оролцох боломж нээлттэй байдаг бөгөөд одоогоор 25 төслийн баг багаа бүрдүүлэн төслөө хэрэгжүүлээд явж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- **“Эрүүл оршихуй”** хөтөлбөрийн хүрээнд
 1. Оюутны эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа
 2. Оюутны эрүүл сэтгэл зүйд чиглэсэн үйл ажиллагаа
 3. Оюутны эрүүл бие бялдарыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
 4. Гоо зүй, хувь хүний хөгжилд чиглэлийн дагуу нийт 40 ажлыг тогтмол зохион байгуулж суралцагчдаа хөгжүүлэх болон зөвлөн тусалдаг давуу талтай.
- **“Оюутны хөгжил”**
 - Эх оронч оюутан
 - Үлгэрлэгч оюутан
 - Эрүүл авъяаслаг оюутан
 - Хөдөлмөрч оюутан дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж суралцагчдаа олон талаар хөгжих боломж олгодог.
- Оюутны эрүүл мэндийг дэмжих төвийг ажиллуулж суралцагчдын эрүүл мэндтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэдэг.
- Оюутны гоо зүй, хувь хүний хөгжлийг төлөвшүүлэх зорилготой “Оюуны галерей” байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн.
- Оюунлаг залуус, Судлаач оюутан зэрэг оюутны эрдэм шинжилгээний хурлуудыг тогтмол зохион байгуулдаг.
- Суралцах хугацаандаа төсөл бичих, хэрэгжүүлэх ур чадвар олгох зорилгоор “Төсөлд суурилсан суралцахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 25 төслийн баг төлөвлөгөө гарган ажиллаж байгаа зэрэг нь давуу тал болж байна.

Зөвлөмж:

- Үйл ажиллагааг зохион байгуулсаны дараа тайланд анхаарах саналаа тусган эргэн сайжруулдаг байх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн 11.000 оюутны төлөөлөл болсон “Оюутны өөрөө удирдах дээд байгууллага” 5 үндсэн албатайгаар үйл ажиллагааг АШУҮИС-ийн оюутны зөвлөлийн дүрмийн дагуу хэрэгжүүлдэг. Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд Сувилахуйн сургуулийн оюутны зөвлөл нь өөрөө удирдах төрийн бус байгууллага ажилладаг бөгөөд оюутны 14 клубыг чиглүүлэн ажилладаг. Оюутны зөвлөлийн харъяанд клубуудын тэргүүн нарын бүрэлдэхүүн бүхий “Клуб зөвлөл”-ийг байгуулан оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд туслах, хамтран ажилладаг. Клубууд нь дүрэм, журам, чиглэлээ тодорхойлон гэрчилгээ авч үйл ажиллагааг явуулдаг. Оюутны зөвлөлийн хүрээнд хийгдэж буй төсөв, санхүүгийн асуудлыг сургууль дэмждэг бөгөөд тайланд тусгагдсан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтмол гарган хавтасжуулсан.
- Мэргэжлийн тэнхим бүр өөрийн харъяа клубтэй мэргэжлийн багш нарын удирдлаган дор 13 клуб идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг.

Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа:

- Дусал цус-Дүүрэн амьдрал-төрийн 6 их сургуулийн 300 багш, ажилтан, оюутан хамруулан 900 хүний амь аварсан.
- Сайн дурын дадлага-Ковид-19-Улаан бүсэд сайн дураар 398 оюутан хамрагдан ажиллаж, үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг тооцуулсан. Өөрсдийн байгаа газраа сайн дурын хэмжээнд хийсэн.
Сайн үйлсийн аян зохион байгуулдаг: Үүнд
-“Халуун сэтгэл”
-“Хайр хуваалцахаас”
-“Ид шидийн уут” зэрэг сайн үйлсийн аян амжилттай хэрэгжүүлсэн.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь цагийн ажилд бүртгэн мэдээллийн санг үүсгэн 2017-2021 онд давхардсан тоогоор 1100 санг үүсгэн 620 гаруй оюутныг цагийн ажилд зуучилсан байна. Ажил олгогч нартай нэгдсэн уулзалтыг зохион байгуулдаг мөн ажил олгогчдын танилцуулгыг сургалтын цахим сайтад байршуулдаг. Мөн сургуульдаа Кофе корнер байгуулан 10 оюутан хичээлээс гадуур ажилладаг.
- Оюутны урлаг, спортын их наадмыг тогтмол зохион байгуулдаг.
- Захирлын нэрэмжит тэтгэлэгийг олгодог бөгөөд сурлагын амжилтаар 18 оюутан, нийгмийн идэвхээр 18 оюутан хамрагдсан. Мөн хамтын ажиллагаатай байгууллагын тэтгэлэгийг 10 оюутан авсан зэрэг олон давуу талууд байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сувилахуйн сургуулийн оюутны зөвлөл нь өөрөө удирдах төрийн бус байгууллага ажилладаг бөгөөд оюутны 14 клубыг чиглүүлэн ажилладаг.
- Мэргэжлийн тэнхим бүр өөрийн харъяа клубтэй мэргэжлийн багш нарын удирдлаган дор 13 клуб идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг.
- Сагс болон гар бөмбөг, олс таталт, ширээний теннис, шатрын спортын дугуйлангууд хичээллэдэг.

- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа:
 - Дусал цус-Дүүрэн амьдрал-төрийн 6 их сургуулийн 300 багш, ажилтан, оюутан хамруулан 900 хүний амь аварсан.
 - Сайн дурын дадлага-Ковид-19-Улаан бүсэд сайн дураар 398 оюутан хамрагдан ажиллаж, үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг тооцуулсан.
 - Сайн үйлсийн аянгууд: Үүнд
 - “Халуун сэтгэл”
 - “Хайр хуваалцахаас”
 - Ид шидийн уут зэрэг сайн үйлсийн аянг амжилттай хэрэгжүүлсэн.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь цагийн ажилд бүртгэн мэдээллийн санг үүсгэн 2017-2021 онд давхардсан тоогоор 1100 санг үүсгэн 620 гаруй оюутныг цагийн ажилд зуучилсан байна.
- Ажил олгогч нартай нэгдсэн уулзалтыг зохион байгуулдаг мөн ажил олгогчдын танилцуулгыг сургалтын цахим сайтанд байршуулдаг.
- Оюутны урлаг, спортын их наадмыг тогтмол зохион байгуулдаг.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг БШУС-ын 2021 оны А/348 дугаар тушаалын 1-р хавсралт болох “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-ын дагуу Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулх журам 2021.01.28 өдрийн А/19 тушаалын 6 заалтын дагуу хэрэгжүүлдэг бөгөөд энэ хичээлийн жилээс журманд өөрчлөлт оруулан оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой өргөдлийг хүлээн авч сар бүр шийдвэрлэдэг болсон. Энэ нь оюутанд ээлтэй байдлыг бий болгож байна.
- Оюутны шилжилт хөдөлгөөнийг 5 чиглэлээр шийдвэрлэн зохион байгуулдаг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулх журам 2021.01.28 өдрийн А/19 тушаалын 7 заалтаар 8 дарааллаар дүнг баталгаажуулан Төгсөлтийн баримт бичгийг монгол, англи, уйгаржин хэлбэрээр UNIMIS программаас шууд хэвлэдэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийг 8 дарааллаар баталгаажуулан төгсөгчдөд хүлээлгэн өгдөг.
- Төгсөлтийн баримт бичгийг монгол, англи, уйгаржин хэлбэрээр UNIMIS программаас шууд хэвлэдэг.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийг сонгон шалгаруулахдаа АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот журмын багшийн сонгон шалгаруулалт заалтыг үндэслэн зохион байгуулдаг. Сонгон шалгуурлах үйл ажиллагааг тэнхим, сургууль, цагийн ачаалалд үндэслэн багшийн хэрэгцээг тодорхойлон нээлттэй зохион байгуулдаг. Мэдээллийг сургуулийн веб хуудас болон сонинд байршуулан нээлттэй зарладаг.
- Багшийг сонгон шалгаруулахдаа шалгалтыг тест болон ярилцлага 2 хэлбэрээр зохион байгуулдаг. Ярилцлагыг “Багшийн хөгжлийн зөвлөл”-өөс хамтран зохион байгуулдаг. Бүрэлдэхүүн сургуулийн захирал болон тэнхимийн эрхлэгч бүрэлдэхүүнд оролцон ярилцлага хийж сонгон шалгаруулдаг.

Багшийн урамшуулал:

- Багшийн эрдэм шинжилгээ бүтээлийн чанарыг нэмэгдүүлэх зорилготой захирлын нэрэмжит судалгааны тэтгэлэг, төслөөс хамаарсан орлогын үзүүлэлттэй холбоотой сургалтын ачааллын хөнгөлөлт, доктор багшийн нэмэгдэл, шилдэг тэнхим, багш, ажлын хэсэг, ажилтан зэргийг шалгаруулж жил бүр урамшуулдаг.
- Докторын тэтгэлэгийг жил бүр тогтмол олгодог
- Албан тушаал давхар хариуцсан тохиолдолд нийт цалингийн 30 хувьтай тэнцэхүйц урамшуулал олгодог.
- Сувилахуйн сургуулийн удирдлагын багийн санаачлагаар 2021 оны 11 сарын 03 өдрийн А/31 тоот тушаалаар Судлаачдад дэмжлэг үзүүлэх тухай урамшууллыг санаачлан хэрэгжүүлж ИФ өндөртэй сэтгүүлийн ранкад үндэслэн урамшуулал олгож одоогоор 1 багшид олгосон байна.
- Багш бүр 8 ажлын хэсэгтээ орж ажиллан үүнээс шилдэг ажлын хэсгийг шалгаруулан урамшуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 75 багш 100 хувь үндсэн багштайгаар сургалтыг зохион байгуулж байгаа нь хөтөлбөрийн хүний нөөцийн хувьд давуу талтай байна.
- Ажилласан жилийн үзүүлэлтээр 21-ээс дээш ажилласан багш нар 31.3 хувийг эзэлж байгаа нь багшийн туршлага өндөр байгааг харуулж байна.
- Мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн 41 багшийн 21.7% нь зөвлөх, 39.1% тэргүүлэх, 39.1% нь ахлах зэрэгтэй байна.
- Сүүлийн 5 жилд БНХАУ болон Тайланд улсад 3 багш, дотоодын их сургуулиудад 2 багш нийт 5 багш докторын зэрэг хамгаалсан.
- Багш, суралцагчдын тоо харьцаа оновчтой.

- Багшийн албан тушаалын зэрэглэлийг 6 түвшинд ангилан хөгжил туршлагын чиглэл, албан тушаалын чиглэл, боловсролын чиглэл, мэргэжлийн чиглэл гэсэн 4 үндсэн чиглэлээр хөгжих боломжийг тодорхой заасан байна. Сүүлийн 5 жилд багш нарын 27.5% нь боловсролын зэрэг, 60.8% нь албан тушаалын зэргээ ахиулсан байна.

Анхаарах асуудал:

- Багш нараас гарсан саналын дагуу багшийн зэрэглэл ахиулахад мэргэжлийн багш нарт тодорхой байдаг боловч ерөнхий эрдмийн буюу өөр мэргэжлийн багш нарт тохиромжтой биш учраас шалгуурыг уян хатан болгоход анхаарах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг бусад төрийн өмчийн 6 сургуультай зөвшилцөн 2021.12 сарын 22-ны А/259 тушаалаар баталсан 4 жилийн хугацаатай батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Заах ба суралцахуй, Эрдэм шинжилгээ судалгаа, Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа, Хувь хүний хөгжил үндсэн 4 чиглэлтэй үүний дагуу календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг.
- Бүрэлдэхүүн сургууль нь Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ хөтөлбөр нь үндэслэл, баримтлах зарчим, удирдлага зохион байгуулт болон үйл ажиллагааны төлөвлөгөө гэсэн бүтэцтэй бөгөөд багшийн хөгжилд зориулан 4 чиглэлээр нарийвчлан төлөвлөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Багшийн хөгжлийн ажлын хэсэг нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлдэг. Төв сургуулиас төлөвлөгөөний дагуу сургалтыг нээлттэй зохион байгуулан гэрчилгээг цахим хэлбэрээр олгодог.
- Шинэ багшид Анагаах ухааны боловсрол судлал чиглэлээр цуврал хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж 2 багц цагийн гэрчилгээ олгодог. Мөн анагаах ухааны боловсрол судлал 1, 2, Судалгааны арга зүйн 8 багц цагийн сургалтанд хамрагдсаны дараа багшлах эрхийн гэрчилгээ олгодог.
- Нийт 8 бүрэлдэхүүн, 3 салбар сургуулийн хүрээнд нээлттэй байдлаар Монгол бичгийн сургалтыг цувралаар зохион байгуулан эхний сургалтыг зохион байгуулсан. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих зорилгоор Анагаах ухааны ёс зүй сэдэвт сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Үүнээс гадна хувь хүний хөгжилтэй холбоотой сургалтууд болон гадаад хэлний сургалтыг зохион байгуулдаг. Эдгээр сургалтуудад сувилахуйн сургуулийн багш нар идэвхтэй хамрагддаг.
- Сувилахуйн сургуулийн хэмжээнд Хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг багш бүр гарган гүйцэтгэлийг тэнхимдээ танилцуулан хэлэлцүүлж, шалгарсан багш нарыг мэргэжлийн тэнхим бүрээс, төлөөллийн багш нар болон удирдлагын болон сургалтын албаны хамтарсан баг хэлэлцүүлж шилдэг багшийг жилдээ 1 удаа шалгаруулан 1 удаагийн урамшуулал олгон бусад багш нарт сайн туршлагыг танилцуулан хуваалцдаг онцлогтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх “Багшийн хөгжлийн зураглал”-ын дагуу “Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө”-г 3 үндсэн хэсгээр боловсруулан тэнхимийн эрхлэгчээр батлуулан хэрэгжүүлдэг. Үр дүнг
 - Сургалтын үйл ажиллагааг 12 асуултаар
 - Эрдэм шинжилгээний үйл ажиллагааг 12 асуултаар
 - Мэргэжлийн үйл ажиллагааг-10 асуултаар нийт 34 асуулга бүхий шалгуураар өөрийн үнэлгээг хийдэг.
- АШУҮИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь багш нараас эрэлт, хүсэлтийн судалгааг 2 жилд 1 удаа авч төлөвлөн нээлттэйгээр цахим болон танхимын хосолсон хэлбэрээр сургалтуудыг зохион байгуулдаг.
- Шинэ багшийг чиглүүлэх сургалтыг зохион байгуулдаг.
- Багшийн хөгжил хариуцсан ажлын хэсэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг.
- Судлаачийн өрөө, цахим хичээл, аудио хичээл бэлтгэх өрөө, дасгал хөдөлгөөн, фитнесийн өрөө зэргийг тохижуулан багш нараа хөгжих боломжийг дэмжин ажиллаж байгаа зэрэг давуу талууд байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан ажлын хэсэг нь үйл ажиллагааны төлөвлөгөө гарган Судалгааны сэдэв сонголт, судалгааны төсөл, Судалгааны статистик боловсруулалт, Судалгааны өгүүлэл бичих багц цагийн сургалтыг сургуулийн хэмжээнд зохион байгуулдаг.
- Сүүлийн 5 жилд гадаадад хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл 38, дотоодод 104, гадаадад хэлэлцүүлсэн илтгэл 123, дотоодод хэлэлцүүлсэн илтгэл 330, Олон улсын IF-тай сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийн тоо 20 байгаа нь багшийн эрдэм шинжлгээ, судалгаа ажил олон улсын түвшинд хийгдэж байгааг харуулж байна.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хан-Уулын нэгдсэн эмнэлэгтэй хамтран хэрэгжүүлж “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4.5” төслийн хүрээнд 48 туслах сувилагчийг бэлтгэн гаргасан.
- Олон улсын Момент төслийг хамтарн хэрэгжүүлж 403.000 еврогийн санхүүжилтийг авсан. Төслийн хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд гадаадад хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл 38, дотоодод 104, гадаадад хэлэлцүүлсэн илтгэл 123, дотоодод хэлэлцүүлсэн илтгэл 330, Олон улсын IF-тай сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийн тоо 20 байгаа нь багшийн эрдэм шинжлгээ, судалгаа ажил олон улсын түвшинд хийгдэж байгааг харуулж байна. Багш нарын бүтээл, судалгаа шинжилгээ, өгүүллийг e-erdem.mn сайтанд байршуулан нээлттэй хүргэдэг.

Зөвлөмж:

- Багш нарын судалгаа шинжилгээ болон хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээс хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам 2021 оны 05 сарын 13-ны өдрийн А/103 тоот журмын Багшийн ажлын үнэлгээ ба багшлах эрхийг баталгаажуулах заалтын дагуу дадлагажигч багш 1 жилд 1 удаа, багш 3 жилд 1 удаа, ахлах болон түүнээс дээш зэрэгтэй багш нар 5 жилд 1 удаа багшийн үнэлгээний журмаар хөндлөнгөөс үнэлүүлэн хөдөлмөрийн гэрээ сунгах болон зэрэг ахих боломжийг олгодог.
- Албан тушаалын зэрэглэлээс хамааран сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа 3 чиглэлээр төлөвлөгөөг гарган тайлангаа бичиж, шалгуур хуудсаар өөрийгөө үнэлээг хийж, үнэлгээний үндэслэл тайлбараа дэлгэрэнгүй тусгадаг. 2021 оноос тайлангийн нотлох баримтуудыг Багшийн ажлын үнэлгээг цахимаар зохион байгуулах удирдамжийн дагуу e-learning программд байршуулан, хөндлөнгөөс Багшийн хөгжлийн зөвлөл үнэлэн зэрэглэл ахиулдаг. Нийт багшийн ажлын өөрийн үнэлгээ нь 70 оноонд суурилан, үлдсэн 30 оноог тэнхимийн эрхлэгч үнэлгээний хуудсын дагуу хөндлөнгөөс үнэлдэг. Энэхүү үнэлгээнд үндэслэн Багшийн хөгжлийн зөвлөл хуваарийн дагуу хөндлөнгийг үнэлгээг хийж эцсийн дүгнэлтийг гаргадаг. Энэ зөвлөлөөс гарсан дүгнэлтийг боловсрол хариуцсан дэд захирал баталгаажуулан хангалттай үнэлгээ авсан тохиолдолд албан тушаалын зэрэглэл ахиулдаг. Багшийн үнэлгээ нь нууцын зэрэглэлтэй бөгөөд үнэлгээг зөвхөн өөрт нь танилцуулдаг.
- Үнэлгээнд орох багш нартаа мэдээллийг урьдчилан өгч уулзаад багш бүрт багш хөгжил цахим сургалтын арга зүйч болон бүрэлдэхүүн сургуулийн арга зүйч нар зөвлөн тусалдаг.
- Багшийн ажлын хавтсыг 100 хувь цахимжуулан программд албан тушаалын зэрэглэлээс хамааран Үндсэн хэсэг, Эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, шагнал урамшуулал, хичээлийн файлын бүрдэлт чиглэлээр сургалт ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл болон нотлох баримтыг файл хэлбэрт оруулж байршуулдаг.
- Гамшигаас хамгаалах тухай хуулийн 34, 37 дугаар зүйл, улсын онцгой комиссын 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоол, МУ-ын ЭМ-ийн Сайдын 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/225 дугаар тушаалын хэрэгжүүлэх зорилгоор АШУҮИС-ийн захирлын 2021 он ыА/84 дугаар тушаалаар АШУҮИС-ийн 1200 оюутны дотуур байранд Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан хөнгөн шинж тэмдэгтэй иргэдийг тусгаарлан, эрүүл мэндийг хянах 392 ортой түр байрыг ажиллуулах болсонтой холбогдуулан халдварын сэргийлэлт, эмнэлзүйн эрэмбэлэлт, оношлогоо, үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн 8 ээлжинд (2021 оны 04 сарын 20-ний өдрийн А/84 тоот тушаал, 2021 оны 04 сарын 29-ний өдрийн А/89 тоот тушаал, 2021 оны 05 сарын 19-ний өдрийн А/105 тоот тушаал, 2021 оны 06 сарын 10-ний өдрийн А/122 тоот тушаал, 2021 оны 06 сарын 28-ний өдрийн А/138 тоот тушаал) Сувилахуйн

сургуулийн нийт 69 (давхардсан тоогоор) багш мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн үнэлгээг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ, оюутны үнэлгээ 5 чиглэлээр 100 хувьд дүйцүүлэн үнэлдэг.
- Суралцагч цахимаар багшийг хөндлөнгөөс үнэлдэг.
- Удирдлага болон зөвлөлийн үнэлгээнд дадлагажигч багш 1 жилд 1 удаа, багш 3 жилд 1 удаа, ахлах болон түүнээс дээш зэрэгтэй багш нар 5 жилд 1 удаа багшийн үнэлгээний журмаар хөндлөнгөөс үнэлүүлэн хөдөлмөрийн гэрээ сунгах болон зэрэг ахих боломжийг олгодог давуу талтай.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны баталгаажилтыг 2016 онд “Юнайтед менежмент консалтинг” ХХК-аар хийлгэн ГЭРЧИЛГЭЭ авсан байна, энэ ажлын хүрээнд 11дотоод аудитор бэлтгэгдсэн. Дотоод аудиторуудыг “Юнайтед менежмент консалтинг” ХХК мөн “Жи эс эй эс” ХХК-ны сургалтуудад сургаж гэрчилгээжүүлсэн байна.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын нотлох баримт бичиг нийт 25 байна. Үүнд: Тушаал, журам, сэтгэл ханамжийн судалгаанууд, ажлын төлөвлөгөө, тайлангууд, тоног төхөөрөмж болон номын сангийн тайлан, багш нарын мэргэжлийн зэргийн ахицын тайлан зэргүүд багтсан байна.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлагын схем, төлөвлөгөө, тушаал, чанарын удирдлагын тогтолцооны гарын авлага, удирдлагын дүн шинжилгээ хийх журам, дотоод аудит хийх журам, үл тохирох бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтын журам, баримт бичгийн хяналтын журам зэргийг гарган ажиллаж байна. Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам хөтөлбөрийг хангах зорилгоор АШУҮИС-ийн захирлын 2021.09.08 өдрийн А/179 тоот тушаал батлагдсан
- Чанарын дотоод болон хөндлөнгийн үнэлгээнд дотоодын аудит хийх журмын дагуу жилийн турш тасралтгүй хяналт үнэлгээ хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Дотоод аудитын 2021 оны үнэлгээнд том үл нийцэл нэг, жижиг үл нийцэл 8 илрүүлж, ажил сайжруулах хугацаат үүрэг өгч ажилласан. Үүнд: гардан ур чадварын өрөөний тоног төхөөрөмжийн ажиллах заавар гаргаж, техник ашиглалтын паспорт ашиглалт хөтөлж, сайжруулсан байна. (том үл нийцэлд)
- Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх ажилуудыг хийж байна. Үүнд: Сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд Олон улсад магадлан итгэмжлүүлэх ажлын тушаал гарсан байна. Мөн нийт 10 сувилагч ОУ-д (Kosi-

Каи, Гунма,Цүкүба) өөрийн мэргэжлээр ажиллаж, суралцаж байгаа бөгөөд тэд сургуулийн үйл ажиллагаа, сургалтанд тогтмол оролцож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Дотоод аудит хийж буй багш нарт аудит хийсэн сард нь нэмэлт урамшуулал цалин олгож байх боломжийг судлах. (100-200 мянга гм) Энэ нь дотоод аудитын хяналт үнэлгээний чанар сайжирна гэж харж байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерын өсөлт, ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацааны судалгааг хийж, үр дүнг харуулсан байна.
- Судалгаанаас төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргахад төгсөөд 1 сар хүртэл хугацаанд 58%, 2-3 сар 28%, 4-6 сар 13% байгаа нь уг сургууль төгсөгчдийн эрэлт өндөр байгааг харуулж байна.
- Сувилагч мэргэжлээр төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд ажил эрхлэлтийн байдалд УБ хотод 76,5%, орон нутагт 26,5% байна. Ажилласан жилээр 1-5 жил 70,4%, 6-11 жил 18,3%, 12-17 жил 7%, 24-29 жил 1,7%, 30 дээш жил 1,7% гм гарсан байна. Өөрийн сургалтанд сэтгэл ханамж санал нийлнэ 89,6%, эмнэл зүйн чадварын эзэмшсэн санал нийлнэ 67,9%, үзлэг хийх ур чадвар эзэмшилт санал нийлнэ 63,5%, зөвлөгөө өгөх чадвар санал нийлнэ 79,2%, төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан 60%, хичээлийн хувиарлалт сайн 95%, ангид оюутны хуваарилалт 97%, материаллаг бааз дундаас дээш үзүүлэлт 86% тус тус гарсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөж буй төгсөгчдийн чадамжид ажил олгогч талууд сэтгэл ханамжтай байдаг.

Анхаарах асуудал:

- Сэтгэл ханамжийн судалгааг өмнөх онуудтой харьцуулан дүгнэж байх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлэх ач холбогдлыг удирдлага, багш, оюутнууд хүлээн зөвшөөрсөн хандлагатай байна.

- Үүнд: APASS 2009 он, БМИҮЗ-д 2010 он, ISO 9001:2015-ыг 2016 он, БМИҮЗ-д 2017 он, БМИҮЗ-д 2022 он, ОУ-ын магадлан 2024 он, ISO 21001:2018-ыг 2025 онд тус тус орсон буюу орохоор төлөвлөсөн байна.
- Боловсролын байгууллагад чанарын удирдлагын тогтолцоо MNSISO9001:2016 болон олон улсын стандартыг МУ-ын боловсролын салбарт анх удаа хэрэгжүүлсэн.
- Чанарын баталгаажуулалтын үйл явцад багш, оюутнуудыг оролцуулан санал хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулж, ажил сайжруулахад хичээлийн агуулга, хичээлийн хэрэглэгдэхүүн, багшийн заах арга зүйд тусгаж байна. (тушаал, журамаар батлагдсан)
- Эмнэлгийн мэргэжлийн зэргийг ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг гэсэн 3 шатлалаар олгохыг ЭМ-ийн тухай хуулийн 2.1-д зааж баталсан байна. Нийт багш нараас зөвлөх зэрэгтэй 5, тэргүүлэх зэрэгтэй 9, ахлах зэрэгтэй 9 байна. Мөн нийт багш нарын 5% дэд профессор, 12% доктор, 83% магистрийн зэрэг хамгаалсан байна.
- Хөтөлбөрийн үнэлгээнд оролцогч, сонирхогч талуудыг жигд татан оролцуулсан байгаа нь цаашид хамтын үйл ажиллагааг сайжруулах, чанаржуулан ажиллах боломж харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндэсний хэмжээнд 2 удаа магадлан итгэмжлүүлж, олон улсын хэмжээний магадланд орох бэлтгэл хангаж байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангааг үй	Үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2 Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			Бүрэн хангасан
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Бүрэн хангасан
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			Бүрэн хангасан
6 Багшийн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			Бүрэн хангасан
Дүгнэлт	Сувилахуйн сургуулийн Сувилахуйн бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан тул магадлан итгэмжлэх саналтай байна.			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Судалгаа, шинжилгээ, эрдэм судлалын ажил нилээдгүй хийсэн боловч түүний үр дүнг хөтөлбөрийн сайжруулалт татан оролцуулах, - Мэргэжлийн онцлогоос шалтгаалан оролцогч талуудын оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх. (Багш, оюутан, төгсөгч, ажил олгогч + эмчлүүлэгч). Тэдний санал хүсэлт, зөвлөмжийг сонсох - Цогц чадамжыг эрэмбэлэх, заавал эзэмшвэл зохих чадамжийг гаргах, хэрэгжүүлэх - Сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт аргыг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн үр дүн болон цогц чадамжийн талаар суралцагч, төгсөгч, ажил олгогч нараас санал асуулга, судалгааг авч тусгадаг байх. Судалгааг тогтмолжуулах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Сургалтын орчин, технологийг улам боловсронгуй болгож, сайжруулах, хөгжүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Бусад орлогын эх үүсвэрийг эрэлхийх - Тэтэглэгт хөтөлбөрийг нэмэгдүүлэх - Өөрийн үнэлгээний тайлан бичихдээ өмнөх 5 жилтэй харьцуулсан байдлаар, ахиц дэвшлийг тодоор харуулж, өөрсдийн оюун дүгнэлтийг хийх
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааг зохион байгуулсаны дараа тайланд анхаарах саналаа тусган эргэн сайжруулдаг байх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багш нарын судалгаа шинжилгээ болон хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээс хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Мэргэжилтний цогц чадамжийг дахин үнэлэх, мэргэжлийн үнэ цэнийг өсгөх

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн “Сувилахуй” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжил”-ийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэгЛ.Уламбаяр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Г.Шүрэнмягмар

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Ю.Оюунзул

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1	Я.Энхжаргал	Дэд профессор	Сувилахуйн судалгаа	99774569
2	Л.Одгэрэл	Ахлах багш	Настаны сувилахуй	94947755
3	В.Ойдов	Дадлагажигч багш	Эрүүл мэндийн үнэлгээ	99034063
4	Б.Буяндэлгэр	Ахлах багш	Философи	99131584
5	Ү.Мөнхдагва	Дадлагажигч багш	Философи	99131584
6	Ж.Энхмаа	Ахлах багш	Эхийн сувилахуй	99155689
7	О.Отгонцэнд	Багш	Сувилахуйн үндэс	99286564
8	Г.Одбаяр	Багш	Эмгэг анатоми физиологи	99179077
9	Ж.Отгонбат	Ахлах багш	Анатоми физиологи	99189877
10	Ч.Энхтуул	Ахлах багш	Дотрын сувилахуй	91918676
11	Л.Хишигдэлгэр	Ахлах багш	Хүүхдийн сувилахуй	99073269
12	Н.Цэцгээ	Багш	Сувилахуйн ур чадвар	88031291

II. Оюутны төлөөлөл

№	Оюутны нэрс	Курс	Сонгогдсон байдал	Утас	Гарын үсэг
1	Х. Одбаяр	I	Нийгмийн идэвхтэй	89999992	
2	А. Тэмүгэ	I	Оюутны зөвлөл	99562551	
3	А.Анужин	I	Нийгмийн идэвхтэй	95820214	
4	А.Намуун	I	Нийгмийн идэвхтэй	99391853	
5	С.Хонгорзул	I	Нийгмийн идэвхтэй	99167781	
6	Б.Базаррагчаа	II	Хүйс	88383310	
7	Н.Ууганбаяр	II	Хүйс	96210229	
8	М.Мягмарлхам	II	Нийгмийн идэвхтэй	89779857	
9	Б.Оюунчимэг	II	Нийгмийн идэвхтэй	89294443	
10	О.Сумъяажав	II	Нийгмийн идэвхтэй	80142556	
11	Б.Содномжаргал	III	Нийгмийн идэвхтэй	88384995	
12	М.Саруул	III	Нийгмийн идэвхтэй	80852646	
13	Н.Адьяа	III	Оюутны зөвлөл	90190441	
14	С.Майцэцэг	III	Нийгмийн идэвхтэй	88525919	
15	А.Мөнхсүвд	III	Нийгмийн идэвхтэй	91323201	
16	Г.Буяннэмэх	IV	Оюутны зөвлөл	86247772	
17	Э.Мөнхтулга	IV	Хүйс	80384989	
18	Ц.Мөнхтуяа	IV	Нийгмийн идэвхтэй	80544211	
19	Г.Отгонсүвд	IV	Оюутны зөвлөл	80299992	
20	Н.Пүрэвдаваа	IV	Хүйс	86626111	

III. Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас
1	Мөнххүслэн	2018	МЯЭ	99699933
2	Номуундарь	2020	Төв эмнэлэг	95212058
3	Маамаа	2018	Завхан аймаг	94191392
4	Одончимэг	2019	Төв аймаг	99277818
5	Ахеркин	2020	Хан-Уул дүүрэг	99755622
6	Дөлгөөн	2021	Интермед	88314569
7	Цэнд-Аюуш	2018	Интермед	86607001
8	Бэрцэцэг	2018	Интермед	80403142
9	Должинсүрэн	2020	Өмнөговь, Сэврэй сумын ЭМТ	86820411
10	Лхагвамаа	2017	УГТЭ	99881394
11	Цэгмид	2019	Сонгдо эмнэлэг	80095547
12	Э.Энх-уянга	2020	ТТАХНЭ	99039330

IV. Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	Ц. Амаржаргал	Улсын 1-р төв эмнэлэг	99165131
2	Д. Өлзийжаргал	Интермед эмнэлэг	99012149
3	О. Алтанцэцэг	ТТАХНЭ	99969660
4	Б. Эрдэнэцэцэг	Эрдэнэт БОЭТ	99364082
5	Г. Цэцэгсүрэн	ХУДНЭ	99902503
6	Ц. Цэнд	ГССҮТ	99273270
7	Т. Энхзаяа	Монгол – Япон эмнэлэг	99142296
8	Ч. Доржмаа	АШУҮИС-ийн төв эмнэлэг	88043450
9	Б. Цогзолмаа	Мөнгөнгүүр эмнэлэг	99024355
10	Н. Ариунболд	СЭМҮТ	99196516

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**МОНГОЛ УЛСЫН АНАГААХЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо,
Ард Аюулийн гудамж,
Улаанбаатар-26 салбар, 189-р шуудангийн хайрцаг,
И-мэйл: nursing@mnum.edu.mn, Веб: nursing.mnum.edu.mn
Утас: 70007633, Факс: 976-70007633

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД**

2022.04.27 № 14/101

танай _____ -ны № _____ -т

Магадлангийн тухай

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Сувилахуйн сургуулийн "Сувилахуй" мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны тайлан, зөвлөмжтэй танилцаад үнэлгээ дүгнэлтийг зөвшөөрч байна.

Цаашид шинжээчийн багаас гарсан зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ



Б. ОЮУНГОО